**Ажлын баримт: 3001**

**Хяналт шинжилгээ хийгдсэн нэгж:**
**НДЕГ болон түүний харьяа байгууллагууд**

# - ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН -

**Аудитын нэр:** Шилэн дансны цахим хуудасны мэдээлэл байршуулалтад хийсэн хяналт шинжилгээний тайлан

**Хамрах хугацаа:** 2025/04/01-2025/09/30

**2025 ОН**

# ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ

| | |
|---|---|
| ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙГДСЭН НЭГЖ: | НДЕГ болон түүний харьяа байгууллагууд |
| ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙГДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА | Шилэн дансны цахим хуудасны мэдээлэл байршуулалт |
| ХАМРАХ ХУГАЦАА : | 2025/04/01-2025/09/30 |
| ГҮЙЦЭТГЭСЭН ХУГАЦАА: | 2025/10/05-2025/10/20 |

ХЯНАСАН:

ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН ГАЗРЫН ДАРГА

Б.ГАНХУЯГ

ГҮЙЦЭТГЭСЭН:

ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

Н.БОЛОРМАА

Э.ЦОЛМОН

Д.ОЮУНТУЯА

Ц.ҮЗМЭЭ

Ж.МӨНХЗУЛ

## АГУУЛГА


1. ҮНДЭСЛЭЛ

2. ЗОРИЛГО

3. ХАМРАХ ХҮРЭЭ

4. АРГА АРГАЧЛАЛ, ТАЙЛАНТ УЛИРАЛД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЛААР

5. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

5.1. Сан
5.2. Үйл ажиллагаа

6. ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДАЛ

7. АВСАН АРГА ХЭМЖЭЭ, ӨГСӨН ЗӨВЛӨМЖ

8. ДҮГНЭЛТ

9. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ, ЗӨВЛӨМЖ

## 1. ҮНДЭСЛЭЛ

1.1. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16.5.6 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ын 8.1 дэх заалт, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 03 дугаар албан даалгавар, Дотоод аудит, мониторингийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэв.

## 2. ЗОРИЛГО

2.1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, хуулийн хугацаанд мэдээ, тайланг үнэн зөв, иж бүрэн байршуулж хэвшүүлэх, хууль, журмын хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэлт, дүгнэлт өгч зөрчлийг арилгахад оршино.

## 3. ХАМРАХ ХҮРЭЭ

3.1. Нийгмийн даатгалын ерөнхий газар, Мэдээллийн технологийн төв, БНСУ дахь ХНХҮ-ний төвийн Нийгмийн даатгалын тасаг, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын байгууллагын үйл ажиллагааны болон нийгмийн даатгалын сангийн 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг дуусталх хугацааны мэдээллийг хамруулав.

## 4. АРГА АРГАЧЛАЛ, ТАЙЛАНТ УЛИРАЛД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЛААР

### 4.1. АРГА АРГАЧЛАЛ

4.1.1. Хяналт шинжилгээг шилэн дансны цахим хуудас (shilendans.gov.mn)-т байршуулсан мэдээллийг харилцах дансдын хуулга, мөнгөн хөрөнгө зарцуулах тухай А, Б тушаал, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, батлагдсан төсөв, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, холбогдох сарын мэдээ зэрэгт үндэслэн хийв.

### 4.2. ТАЙЛАНТ УЛИРАЛД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ

4.2.1. Тайлант хугацаанд шилэн дансны мэдээлэл байршуулалттай холбоотой дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Шилэн дансны хөтлөлтийн 2025 оны 01, 02 дугаар улирлын тайланг гаргаж Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны 02/912 дугаар албан бичгээр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны "Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах тухай" 03 дугаар албан даалгаврын биелэлтийг 2025 оны 02 дугаар улирлын байдлаар гаргаж Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны 02/1719 дүгээр албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.
- Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрууд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2025 оны 02 дугаар улирлын байдлаар хяналт-шинжилгээ хийж, тоон мэдээ, тайланг 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн дотор тус газарт ирүүлэх тухай Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны "Ажил зохион байгуулах

тухай" 02/1583 дугаар албан бичиг, мөн дээрх албан бичгийн хариуг хангалтгүй ирүүлсэн тул дахин тайлан мэдээг ирүүлэх талаар 2025 оны "Мэдээ тайлан ирүүлэх тухай" 02/1682 дугаар албан бичгийг Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газарт тус тус хүргүүлсэн.

Дээрх албан бичгийн хариуг Булган, Говьсүмбэр, Дорнод, Завхан, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс аймаг, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газрууд ирүүлээгүй байна.

## 5. ҮР ДҮН

### 5.1. НЭГДСЭН ДҮН

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оны эхний 9 сарын байдлаар шилэн дансны цахим хуудаст Нийгмийн даатгалын байгууллагын болон нийгмийн даатгалын сангийн нийт 183,809 шийдвэр гүйлгээний 166,791,578.1 сая төгрөгийн 8,745 мэдээлэл байршуулахаас 8,202 мэдээллийг хугацаанд нь мэдээлж мэдээлэл байршуулалт 97.3 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 93.8 хувьтай байна.

*Хугацаандаа мэдээлсэн 8,202 мэдээллийн:*

- Хугацаандаа мэдээлсэн 3,727 мэдээлэл;
- "Оруулах мэдээлэл байхгүй" төлөвөөр мэдээлсэн 4,475 мэдээлэл байна.

Мэдээлэл байршуулалтыг аймаг, дүүргээр харуулбал:

/сая.төгрөг/

| Д/д | Газрын нэр | Нийт мэдээлэх | | Мэдээлэл хугацаандаа оруулсан | Хугацаа хоцорсон мэдээлэл | | Мэдээлээгүй | | Нийт мэдээлэл байршуулсан хувь | Хугацаандаа мэдээлэл байршуулсан хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Мэдээллийн тоо | Мөнгөн дүн | | Мэдээллийн тоо | Мөнгөн дүн | Мэдээллийн тоо | Мөнгөн дүн | | |
| 1 | Архангай | 273 | 1,688,500.0 | 261 | 3 | 177.4 | 9 | 4,527.3 | 97% | 96% |
| 2 | Баян-Өлгий | 273 | 1,397,959.7 | 257 | 12 | 105,838.4 | 4 | 7,012.8 | 99% | 94% |
| 3 | Баянхонгор | 273 | 1,961,700.4 | 230 | 18 | 22,519.6 | 25 | 1,096,982.1 | 91% | 84% |
| 4 | Булган | 273 | 1,220,125.1 | 246 | 25 | 175,265.8 | 2 | 167,117.9 | 99% | 90% |
| 5 | Говь-Алтай | 273 | 932,544.0 | 262 | 11 | 99,925.8 | - | 40,081.9 | 100% | 96% |
| 6 | Говьсүмбэр | 273 | 487,102.2 | 261 | 3 | 63,168.6 | 9 | - | 97% | 96% |
| 7 | Дархан-Уул | 273 | 2,662,059.2 | 257 | 2 | 2,066.3 | 14 | 356,317.7 | 95% | 94% |
| 8 | Дорноговь | 273 | 1,462,567.9 | 268 | 3 | 4,418.0 | 2 | 461,687.1 | 99% | 98% |
| 9 | Дорнод | 273 | 1,555,712.5 | 252 | 14 | 111,465.3 | 7 | 43,237.4 | 97% | 92% |
| 10 | Дундговь | 273 | 857,595.8 | 262 | 5 | 59,484.1 | 6 | 11,195.1 | 98% | 96% |
| 11 | Завхан | 273 | 2,190,067.6 | 264 | 9 | 211,250.8 | - | - | 100% | 97% |
| 12 | Орхон | 273 | 3,343,158.0 | 260 | 12 | 4,316.4 | 1 | 5.1 | 100% | 95% |
| 13 | Өвөрхангай | 273 | 1,864,487.4 | 265 | 6 | 28,544.5 | 2 | 218.5 | 99% | 97% |
| 14 | Өмнөговь | 273 | 2,230,695.5 | 266 | 1 | 352,335.1 | 6 | 423,061.5 | 98% | 97% |
| 15 | Сухбаатар | 273 | 5,467,622.9 | 259 | 4 | 648.4 | 10 | 31,836.0 | 96% | 95% |
| 16 | Сэлэнгэ | 273 | 2,507,974.5 | 243 | 4 | 36,062.7 | 26 | 483,784.8 | 90% | 89% |
| 17 | Төв | 273 | 1,799,183.6 | 236 | 37 | 496,206.0 | - | 769.5 | 100% | 86% |
| 18 | Увс | 273 | 2,182,994.2 | 259 | 4 | 120,533.7 | 10 | 14,714.3 | 96% | 95% |
| 19 | Ховд | 273 | 1,725,685.7 | 257 | 10 | 76,978.5 | 6 | 1,037.4 | 98% | 94% |
| 20 | Хөвсгөл | 273 | 2,001,157.8 | 239 | 7 | 156,094.8 | 27 | 436,491.3 | 90% | 88% |
| 21 | Хэнтий | 273 | 1,623,263.7 | 252 | 18 | 1,212.3 | 3 | 172.0 | 99% | 92% |
| 22 | Багануур | 273 | 855,930.0 | 265 | 6 | 41,161.2 | 2 | 6.4 | 99% | 97% |
| 23 | Багахангай | 273 | 99,945.4 | 257 | 16 | 14,077.1 | - | - | 100% | 94% |
| 24 | Баянгол | 273 | 8,149,311.0 | 266 | 7 | 130,275.3 | - | - | 100% | 97% |
| 25 | Баянзүрх | 273 | 7,284,825.7 | 249 | 9 | 176,419.8 | 15 | 46.2 | 95% | 91% |
| 26 | Налайх | 273 | 924,464.4 | 250 | 20 | 129,118.7 | 3 | 136,345.7 | 99% | 92% |
| 27 | Сонгинохайрхан | 273 | 6,094,219.6 | 270 | 1 | 1,219.3 | 2 | 1,329.8 | 99% | 99% |
| 28 | Сүхбаатар дүүрэг | 273 | 6,292,937.1 | 266 | 4 | 34.4 | 3 | 32,541.2 | 99% | 97% |
| 29 | Хан-Уул | 273 | 6,906,008.6 | 273 | - | - | - | - | 100% | 100% |
| 30 | Чингэлтэй НДГ | 273 | 6,109,541.3 | 227 | 16 | 805,601.8 | 30 | 1,743,805.3 | 89% | 83% |
| 31 | БНСУ дахь | 132 | 7,338.5 | 118 | 8 | 421.2 | 6 | 6,281.6 | 95% | 89% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ХНХҮ-ний төвийн НД-ын тасаг | | | | | | | | | |
| 32 | НДЕГ-МТТ | 141 | 15,120.0 | 140 | 1 | - | - | - | 100% | 99% |
| 33 | НДЕГ | 282 | 82,889,778.7 | 265 | 14 | 988,686.3 | 3 | 1,319,204.4 | 99% | 94% |
| **НИЙТ** | | **8,745** | **166,791,578.1** | **8,202** | **310** | **4,415,527.4** | **233** | **6,819,810.1** | **97.3%** | **93.8%** |

Хяналт шинжилгээгээр нийт 14,410,010.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс:

- 20,039 шийдвэр гүйлгээний 6,819,810.1 сая төгрөгийн 233 мэдээллийг мэдээлээгүй;
- 3,233 шийдвэр гүйлгээний 3,174,673.3 сая төгрөгийн мэдээллийг илүү мэдээлсэн;
- 778,530 шийдвэр гүйлгээний 4,415,527.4 сая төгрөгийн 310 мэдээллийг 333,422 хоног хугацаа хоцроож мэдээлсэн ба хяналт шинжилгээний явцад зөрчлийг залруулж нөхөн мэдээлсэн 2,012 шийдвэр гүйлгээний 472,884.6 сая төгрөгийн мэдээлэл байна.

Мэдээлээгүй болон дутуу мэдээлсэн 11,235,337.5 сая төгрөгийн 543 мэдээлэл байгаа бөгөөд энэ нь нийт мэдээллийн 6.2 хувийг эзэлж байна. Үүнд:

- Мэдээлээгүй 233 мэдээлэл байгаа нь нийт мэдээллийн 2.7 хувь;
- Хугацаа хоцроосон 310 мэдээлэл байгаа нь нийт мэдээллийн 3.5 хувийг эзэлж байна.

*Дээрх хүснэгтээс харахад:* Хугацаандаа мэдээлэл байршуулсан байдал Баянхонгор аймагт 84 хувь, Булган аймагт 90 хувь, Дорнод аймагт 92 хувь, Сэлэнгэ аймагт 89 хувь, Төв аймагт 86 хувь, Хөвсгөл аймагт 88 хувь, Хэнтий аймагт 92 хувь, Баянзүрх дүүрэгт 91 хувь, Налайх дүүрэгт 92 хувь, Чингэлтэй дүүрэгт 83 хувь, БНСУ дахь ХНХҮ-ний төвийн НД-ын тасагт 89 хувьтай байна.

### *5.2. Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл байршуулалт:*

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газар, БНСУ дахь ХНХҮ-ний төвийн НД-ын тасаг, 9 дүүрэг, 21 аймгийн Нийгмийн даатгалын сангийн 32 хэрэглэгчээр шилэн дансны цахим хуудас (shilendans.gov.mn)-т Нийгмийн даатгалын сангийн *Төсөв, гүйцэтгэл* төрөлд 12, *Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт* төрөлд 5, *Бусад* төрөлд 8 нийт 25 төрлийн мэдээллийг байршуулан хэрэглэгчид нийгмийн даатгалын сангийн мэдээлэлтэй танилцах боломжийг хангаж ажиллаж байна.

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оны эхний 9 сарын байдлаар шилэн дансны цахим хуудаст Нийгмийн даатгалын сангийн нийт 180,422 шийдвэр гүйлгээний 166,242,196.9 сая төгрөгийн 4,233 мэдээлэл байршуулахаас 4,085 мэдээллийг хугацаанд нь мэдээлж мэдээлэл байршуулалт 98.1 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 96.5 хувьтай байна.

Мэдээлэл байршуулалтыг аймаг, дүүргээр харуулбал:

/сая.төгрөг/

| Д/д | Газрын нэр | Нийт мэдээлэх | | | Хугацаандаа оруулсан | Хугацаа хоцорсон мэдээлэл | Үүнээс | | Мэдээлээгүй | | | Нийт мэдээлэл байршуулсан хувь | Хугацаандаа мэдээлэл байршуулсан хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Мэдээллийн тоо | Шийдвэр, гүйлгээний тоо | Мөнгөн дүн | | | Шийдвэр, гүйлгээний тоо | Мөнгөн дүн | Мэдээллийн тоо | Шийдвэр, гүйлгээний тоо | Мөнгөн дүн | | |
| 1 | Архангай | 132 | 2,862 | 1,674,095.6 | 130 | - | - | - | 2 | - | 4,298.7 | 98% | 98% |
| 2 | Баян-Өлгий | 132 | 3,122 | 1,384,593.9 | 126 | 6 | 940 | 105,176.5 | - | 99 | 6,708.1 | 100% | 95% |
| 3 | Баянхонгор | 132 | 3,234 | 1,946,135.1 | 109 | - | 10 | 18,760.0 | 23 | 23 | 1,096,764.6 | 83% | 83% |
| 4 | Булган | 132 | 2,426 | 1,198,411.4 | 130 | 2 | 73 | 167,114.2 | - | 73 | 167,114.2 | 100% | 98% |
| 5 | Говь-Алтай | 132 | 2,434 | 917,547.8 | 128 | 4 | 1 | 97,422.8 | - | 5 | 40,081.9 | 100% | 97% |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Говьсүмбэр | 132 | 1,350 | 480,668.2 | 131 | - | 6 | 63,151.6 | 1 | - | - | 99% | 99% |
| 7 | Дархан-Уул | 132 | 4,475 | 2,646,083.0 | 132 | - | - | - | - | 1 | 354,095.6 | 100% | 100% |
| 8 | Дорноговь | 132 | 3,702 | 1,448,189.3 | 130 | - | 89 | 4,358.0 | 2 | 2 | 461,618.0 | 98% | 98% |
| 9 | Дорнод | 132 | 3,476 | 1,542,747.7 | 125 | 5 | 853 | 111,428.6 | 2 | 190 | 42,938.6 | 98% | 95% |
| 10 | Дундговь | 132 | 1,978 | 845,084.2 | 125 | 5 | 564 | 59,484.1 | 2 | 86 | 11,122.3 | 98% | 95% |
| 11 | Завхан | 132 | 3,006 | 2,164,523.0 | 129 | 3 | 1 | 208,793.2 | - | - | - | 100% | 98% |
| 12 | Орхон | 132 | 3,902 | 3,330,962.5 | 132 | - | - | - | - | - | - | 100% | 100% |
| 13 | Өвөрхангай | 132 | 3,571 | 1,846,367.4 | 130 | 1 | 233 | 26,289.2 | 1 | 1 | 179.2 | 99% | 98% |
| 14 | Өмнөговь | 132 | 5,519 | 2,217,142.9 | 127 | 1 | 1 | 352,335.1 | 4 | 1 | 423,047.7 | 97% | 96% |
| 15 | Сухбаатар | 132 | 2,086 | 5,454,963.3 | 132 | - | - | - | - | - | 31,832.1 | 100% | 100% |
| 16 | Сэлэнгэ | 132 | 4,228 | 2,489,425.2 | 127 | 2 | 742 | 35,670.9 | 3 | 588 | 483,120.2 | 98% | 96% |
| 17 | Төв | 132 | 3,498 | 1,777,469.9 | 124 | 8 | 4 | 488,054.4 | - | 17 | 765.8 | 100% | 94% |
| 18 | Увс | 132 | 3,331 | 2,167,208.4 | 131 | 1 | 1 | 120,445.1 | - | 2,871 | 10,801.1 | 100% | 99% |
| 19 | Ховд | 132 | 3,658 | 1,709,677.9 | 130 | 2 | - | 76,417.0 | - | - | - | 100% | 98% |
| 20 | Хөвсгөл | 132 | 3,909 | 1,983,322.2 | 122 | 5 | 1,341 | 155,905.7 | 5 | 542 | 433,676.7 | 96% | 92% |
| 21 | Хэнтий | 132 | 3,439 | 1,613,005.3 | 131 | - | - | - | 1 | 10 | 162.6 | 99% | 99% |
| 22 | Багануур | 132 | 1,561 | 847,739.5 | 131 | - | 418 | 41,138.5 | 1 | 1 | - | 99% | 99% |
| 23 | Багахангай | 132 | 495 | 98,132.2 | 129 | 3 | 1 | 13,616.5 | - | - | - | 100% | 98% |
| 24 | Баянгол | 132 | 19,122 | 8,126,774.0 | 131 | 1 | 361 | 127,563.0 | - | - | - | 100% | 99% |
| 25 | Баянзүрх | 132 | 14,899 | 7,257,813.7 | 127 | 2 | 1,359 | 175,324.9 | 3 | - | - | 98% | 96% |
| 26 | Налайх | 132 | 1,391 | 915,070.3 | 125 | 6 | 749 | 127,136.9 | 1 | 12 | 136,316.0 | 99% | 95% |
| 27 | Сонгинохайрхан | 132 | 5,373 | 6,072,646.5 | 132 | - | - | - | - | - | - | 100% | 100% |
| 28 | Сүхбаатар дүүрэг | 132 | 16,277 | 6,269,985.9 | 130 | - | - | - | 2 | - | 32,255.5 | 98% | 98% |
| 29 | Хан-Уул | 132 | 15,844 | 6,884,534.4 | 132 | - | - | - | - | - | - | 100% | 100% |
| 30 | Чингэлтэй | 132 | 14,266 | 6,094,987.9 | 114 | - | 770,269 | 799,986.8 | 18 | 14,238 | 1,742,940.3 | 86% | 86% |
| 31 | БНСУ дахь ХНХҮ-ний төвийн НД-ын тасаг | 132 | 46 | 7,338.5 | 118 | 8 | 40 | 421.2 | 6 | 2 | 6,281.6 | 95% | 89% |
| 32 | НДЕГ төв сан | 141 | 21,942 | 82,829,549.7 | 135 | 3 | 6 | 972,398.0 | 3 | 982 | 1,319,204.4 | 98% | 96% |
| **НИЙТ** | | **4,233** | **180,422** | **166,242,196.9** | **4,085** | **68** | **778,062** | **4,348,392.2** | **80** | **19,744** | **6,805,325.3** | **98%** | **97%** |

Хяналт шинжилгээгээр нийт 14,243,373.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс:

- 19,744 шийдвэр гүйлгээний 6,805,325.3 сая төгрөгийн 80 мэдээллийг мэдээлээгүй;
- 2,318 шийдвэр гүйлгээний 3,089,655.9 сая төгрөгийн мэдээллийг илүү мэдээлсэн;
- 778,062 шийдвэр гүйлгээний 4,348,392.2 сая төгрөгийн 68 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн ба хяналт шинжилгээний явцад зөрчлийг залруулж нөхөн мэдээлсэн 1,921 шийдвэр гүйлгээний 464,744.0 сая төгрөгийн мэдээллийг 324,357 хоног хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Мэдээлээгүй, мөн дутуу мэдээлсэн 11,153,717.5 сая төгрөгийн 148 мэдээлэл байгаа бөгөөд энэ нь нийт мэдээллийн 3.5 хувийг эзэлж байна.

*Дээрх хүснэгтээс харахад*: Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрууд тус бүртээ 132 мэдээлэл мэдээлэхээс Архангай аймаг 2, Баянхонгор аймаг 23, Говьсүмбэр аймаг 1, Дорноговь аймаг 2, Дорнод аймаг 2, Дундговь аймаг 2, Өвөрхангай аймаг 1, Өмнөговь аймаг 4, Сэлэнгэ аймаг 3, Хөвсгөл аймаг 5, Хэнтий аймаг 1, Багануур дүүрэг 1, Баянзүрх дүүрэг 3, Налайх дүүрэг 1, Сүхбаатар дүүрэг 2, Чингэлтэй дүүрэг 18, БНСУ дахь ХНХҮ-ний төвийн НД-ын тасаг 6, НДЕГ төв сан 3 мэдээлэл мэдээлээгүй байна.

*Тайлбар*: Хугацаа хоцроосон мэдээллийг шилэн дансны цахим хуудасны хэрэглэгч талаас харагдах мэдээллээр бус мэдээлэл доторх хугацаа хоцроосон байдлаар тооцсон.

Мөн Мэдээллийн технологийн төв нь 2025 оны 1-9 дүгээр сарын харилцах дансны хуулгыг ирүүлээгүй тул Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягтай холбоотой мэдээллийг тулган шалгаагүй болно.

Мэдээлээгүй буюу цахим хуудсанд байршуулаагүй мэдээллийг мэдээллийн *төрлөөр* нь авч үзвэл:

/сая.төгрөг/

| Д/д | Шилэн дансны мэдээллийн төрлийн нэр | Нийт мэдээлэх | | Хугацаандаа оруулсан | Хугацаа хоцорсон мэдээлэл | | Мэдээлээгүй | | Нийт мэдээлэл байршуулсан хувь | Хугацаандаа мэдээлэл байршуулсан хувь | Мэдээлээгүй буюу хугацаа хоцроосон мэдээллийн төрөл тус бүрт эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Мэдээллийн тоо | Шийдвэр, гүйлгээний тоо | | Мэдээллийн тоо | Шийдвэр, гүйлгээний тоо | Мэдээллийн тоо | Шийдвэр, гүйлгээний тоо | | | |
| 1 | Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-Эдийн засгийн ангилал | 288 | 270 | 275 | 2 | 1 | 11 | 9 | 96% | 95% | 4.5% |
| 2 | Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл-Хөтөлбөр, зориулалт | 288 | 270 | 276 | 1 | - | 11 | 12 | 96% | 96% | 4.2% |
| 3 | Санхүүгийн тайлан /2024 оны жилийн эцэс, 2025 оны эхний хагас жил/ | 64 | 57 | 59 | 3 | 5 | 2 | - | 97% | 92% | 7.8% |
| 4 | Хандив, тусламжийн орлого | 64 | - | 62 | 1 | - | 1 | - | 98% | 97% | 3.1% |
| 5 | Хандив, тусламжийн зарцуулалтын тайлан | 64 | - | 62 | 1 | - | 1 | - | 98% | 97% | 3.1% |
| 6 | Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан | 64 | - | 62 | 1 | - | 1 | - | 98% | 97% | 3.1% |
| 7 | Байгууллагын батлагдсан төсөв | 32 | 34 | 28 | 2 | 3 | 2 | 2 | 94% | 88% | 12.5% |
| 8 | Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /2024 оны жилийн эцэс/ | 32 | 12 | 30 | 2 | 1 | 0 | 1 | 100% | 94% | 6.3% |
| 9 | Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ | 288 | 135,982 | 249 | 24 | 14,200 | 15 | 14,080 | 95% | 86% | 13.5% |
| 10 | Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ | 288 | 43,466 | 250 | 21 | 763,843 | 17 | 5,625 | 94% | 87% | 13.2% |
| 11 | Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт | 288 | 116 | 278 | 1 | 3 | 9 | 13 | 97% | 97% | 3.5% |
| 12 | Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл | 288 | 0 | 287 | 0 | - | 1 | - | 100% | 100% | 0.3% |
| 13 | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө | 32 | 5 | 30 | 2 | 4 | 0 | 1 | 100% | 94% | 6.3% |
| 14 | Худалдан авах ажиллагааны тайлан /2024 он/ | 32 | 4 | 31 | 0 | - | 1 | - | 97% | 97% | 3.1% |
| 15 | Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл | 288 | 0 | 287 | 0 | - | 1 | - | 100% | 100% | 0.3% |
| 16 | Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт | 288 | 0 | 288 | 0 | - | 0 | - | 100% | 100% | 0.0% |
| 17 | Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан | 32 | 35 | 29 | 0 | - | 3 | 1 | 91% | 91% | 9.4% |
| 18 | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл | 288 | 0 | 285 | 0 | - | 3 | - | 99% | 99% | 1.0% |
| 19 | Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн | 288 | 1 | 287 | 0 | - | 1 | - | 100% | 100% | 0.3% |
| 20 | Хавсралт файлууд | 288 | 0 | 283 | 5 | - | 0 | - | 100% | 98% | 1.7% |
| 21 | Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн талаарх мэдээлэл** | 9 | 135 | 7 | 2 | 2 | 0 | - | 100% | 78% | 22.2% |
| **НИЙТ** | | **4,233** | **180,422** | **4,085** | **68** | **778,062** | **80** | **19,744** | **98.1%** | **96.5%** | **3.5%** |

*Дээрх хүснэгтээс харахад*: Нийт мэдээлээгүй, хугацаа хоцроосон 148 мэдээллийн /3.5 хувь/:

- 129 мэдээлэл /3.1 хувь/ нь ***Төсөв, гүйцэтгэл*** төрөлд;
- 5 мэдээлэл /0.1 хувь/ нь ***Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт*** төрөлд;

- 14 мэдээлэл /0.3 хувь/ нь ***Бусад*** төрөлд тус тус байна.

### *5.3. Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл байршуулалт*

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газар, Мэдээллийн технологийн төв, 9 дүүрэг, 21 аймгийн Нийгмийн даатгалын газрын 32 хэрэглэгчээр шилэн дансны цахим хуудас (shilendans.gov.mn)-т Нийгмийн даатгалын байгууллагын *Төсөв, гүйцэтгэл* төрөлд 12, *Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт* төрөлд 6, *Бусад* төрөлд 7, нийт 25 төрлийн мэдээллийг байршуулан хэрэглэгчид нийгмийн даатгалын байгууллагын мэдээлэлтэй танилцах боломжийг ханган ажиллаж байна.

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оны эхний 9 сарын байдлаар шилэн дансны цахим хуудаст Нийгмийн даатгалын байгууллагын нийт 3,387 шийдвэр гүйлгээний 549,381.2 сая төгрөгийн 4,512 мэдээлэл байршуулахаас 4,117 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 242 мэдээллийг хугацаа хоцроож, 153 мэдээллийг мэдээлээгүй байна. Мэдээлэл байршуулалт 96.6 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 91.2 хувьтай байна.

Мэдээлэл байршуулалтыг аймаг, дүүргээр харуулбал:

/сая.төгрөг/

| Д/д | Газрын нэр | Нийт мэдээлэх | | | Хугацаанда а оруулсан мэдээллийн тоо | Хугацаа хоцорсон мэдээлэл | | | Мэдээлээгүй | | | Нийт мэдээлэл байршуулсан хувь | Хугацаандаа байршуулсан мэдээллийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Мэдээллийн тоо | Шийдвэр, гүйлгээний тоо | Мөнгөн дүн | | Мэдээллийн тоо | Шийдвэр, гүйлгээний тоо | Мөнгөн дүн | Мэдээллийн тоо | Шийдвэр, гүйлгээний тоо | Мөнгөн дүн | | |
| 1 | Архангай | 141 | 90 | 14,404.4 | 131 | 3 | 5 | 177.4 | 7 | 10 | 228.5 | 95% | 93% |
| 2 | Баян-Өлгий | 141 | 80 | 13,365.8 | 131 | 6 | 13 | 661.9 | 4 | 17 | 304.7 | 97% | 93% |
| 3 | Баянхонгор | 141 | 115 | 15,565.3 | 121 | 18 | 35 | 3,759.6 | 2 | 14 | 217.5 | 99% | 86% |
| 4 | Булган | 141 | 103 | 21,713.7 | 116 | 23 | 46 | 8,151.6 | 2 | 4 | 3.7 | 99% | 82% |
| 5 | Говь-Алтай | 141 | 64 | 14,996.2 | 134 | 7 | 12 | 2,503.0 | - | - | - | 100% | 95% |
| 6 | Говьсүмбэр | 141 | 114 | 6,434.0 | 130 | 3 | 6 | 17.0 | 8 | 7 | - | 94% | 92% |
| 7 | Дархан-Уул | 141 | 69 | 15,976.2 | 125 | 2 | 8 | 2,066.3 | 14 | 14 | 2,222.1 | 90% | 89% |
| 8 | Дорноговь | 141 | 155 | 14,378.6 | 138 | 3 | 3 | 60.0 | - | 4 | 69.1 | 100% | 98% |
| 9 | Дорнод | 141 | 105 | 12,964.8 | 127 | 9 | 5 | 36.7 | 5 | 9 | 298.8 | 96% | 90% |
| 10 | Дундговь | 141 | 70 | 12,511.6 | 137 | - | - | - | 4 | 17 | 72.8 | 97% | 97% |
| 11 | Завхан | 141 | 90 | 25,544.6 | 135 | 6 | 24 | 2,457.6 | - | - | - | 100% | 96% |
| 12 | Орхон | 141 | 90 | 12,195.5 | 128 | 12 | 21 | 4,316.4 | 1 | 9 | 5.1 | 99% | 91% |
| 13 | Өвөрхангай | 141 | 189 | 18,120.0 | 135 | 5 | 9 | 2,255.3 | 1 | 1 | 39.3 | 99% | 96% |
| 14 | Өмнөговь | 141 | 88 | 13,552.6 | 139 | - | - | - | 2 | 2 | 13.8 | 99% | 99% |
| 15 | Сухбаатар | 141 | 212 | 12,659.6 | 127 | 4 | 15 | 648.4 | 10 | 10 | 3.9 | 93% | 90% |
| 16 | Сэлэнгэ | 141 | 126 | 18,549.3 | 116 | 2 | 6 | 391.8 | 23 | 16 | 664.6 | 84% | 82% |
| 17 | Төв | 141 | 103 | 21,713.7 | 112 | 29 | 46 | 8,151.6 | - | 4 | 3.7 | 100% | 79% |
| 18 | Увс | 141 | 119 | 15,785.8 | 128 | 3 | 5 | 88.6 | 10 | 59 | 3,913.1 | 93% | 91% |
| 19 | Ховд | 141 | 64 | 16,007.7 | 127 | 8 | 12 | 561.5 | 6 | 11 | 1,037.4 | 96% | 90% |
| 20 | Хөвсгөл | 141 | 94 | 17,835.6 | 117 | 2 | 4 | 189.1 | 22 | 26 | 2,814.6 | 84% | 83% |
| 21 | Хэнтий | 141 | 78 | 10,258.5 | 121 | 18 | 27 | 1,212.3 | 2 | 1 | 9.4 | 99% | 86% |
| 22 | Багануур | 141 | 83 | 8,190.5 | 134 | 6 | 4 | 22.7 | 1 | 1 | 6.4 | 99% | 95% |
| 23 | Багахангай | 141 | 64 | 1,813.2 | 128 | 13 | 16 | 460.6 | - | - | - | 100% | 91% |
| 24 | Баянгол | 141 | 76 | 22,537.0 | 135 | 6 | 17 | 2,712.3 | - | - | - | 100% | 96% |
| 25 | Баянзүрх | 141 | 99 | 27,012.0 | 122 | 7 | 28 | 1,094.9 | 12 | 1 | 46.2 | 91% | 87% |
| 26 | Налайх | 141 | 70 | 9,394.1 | 125 | 14 | 23 | 1,981.8 | 2 | 4 | 29.7 | 99% | 89% |
| 27 | Сонгинохайрхан | 141 | 308 | 21,573.1 | 138 | 1 | 1 | 1,219.3 | 2 | 4 | 1,329.8 | 99% | 98% |
| 28 | Сүхбаатар дүүрэг | 141 | 80 | 22,951.2 | 136 | 4 | 8 | 34.4 | 1 | 3 | 285.8 | 99% | 96% |
| 29 | Хан-Уул | 141 | 62 | 21,474.1 | 141 | - | - | - | - | - | - | 100% | 100% |
| 30 | Чингэлтэй | 141 | 116 | 14,553.4 | 113 | 16 | 21 | 5,615.0 | 12 | 47 | 865.0 | 91% | 80% |
| 31 | НДЕГ-МТТ | 141 | 61 | 15,120.0 | 140 | 1 | - | - | - | - | - | 100% | 99% |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 32 | НДЕГ | 141 | 150 | 60,229.0 | 130 | 11 | 48 | 16,288.3 | - | - | - | 100% | 92% |
| | | **4,512** | **3,387** | **549,381.2** | **4,117** | **242** | **468** | **67,135.2** | **153** | **295** | **14,484.8** | **97%** | **91%** |

Хяналт шинжилгээгээр нийт 166,637.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс:

- 295 шийдвэр гүйлгээний 14,484.8 сая төгрөгийн 153 мэдээллийг мэдээлээгүй;
- 915 шийдвэр гүйлгээний 85,017.3 сая төгрөгийн мэдээллийг илүү мэдээлсэн;
- 468 шийдвэр гүйлгээний 67,135.2 сая төгрөгийн 242 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн ба хяналт шинжилгээний явцад зөрчлийг залруулж нөхөн мэдээлсэн 91 шийдвэр гүйлгээний 8,140.6 сая төгрөгийн мэдээлэл байна.

*Дээрх хүснэгтээс харахад*: Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрууд тус бүр 141 мэдээлэл мэдээлэхээс Хан-Уул дүүрэг, Дундговь, Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын газраас бусад аймаг, дүүргүүд 1-29 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь нийт мэдээллийн 5.36 хувийг эзэлж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газар 11, Баян-Өлгий аймаг 6, Баянхонгор аймаг 7, Булган аймаг 23, Дорнод аймаг 9, Орхон аймаг 12, Төв аймаг 29, Ховд аймаг 8, Хэнтий аймаг 18, Багахангай дүүрэг 13, Налайх дүүрэг 14, Чингэлтэй дүүрэг 16 мэдээлэл мэдээлээгүй болон хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Мэдээлээгүй, мөн дутуу мэдээлсэн 14,484.8 сая төгрөгийн 153 мэдээлэл байгаа бөгөөд энэ нь нийт мэдээллийн 3.39 хувийг эзэлж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газар, Говь-Алтай, Дорноговь, Завхан, Төв аймаг, Багахангай, Баянгол, Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын газраас бусад аймаг, дүүргүүд 1-23 мэдээллийг мэдээлээгүй нь нийт мэдээллийн 5.36 хувийг эзэлж байна.

Архангай аймаг 7, Баян-Өлгий аймаг 4, Баянхонгор аймаг 2, Булган аймаг 2, Говьсүмбэр аймаг 8, Дархан-Уул аймаг 14, Дорнод аймаг 5, Дундговь аймаг 4, Орхон аймаг 1, Өвөрхангай аймаг 1, Өмнөговь аймаг 2, Сүхбаатар аймаг 10, Сэлэнгэ аймаг 23, Увс аймаг 10, Ховд аймаг 6, Хөвсгөл аймаг 22, Хэнтий аймаг 2, Багануур дүүрэг 1, Баянзүрх дүүрэг 12, Налайх дүүрэг 2, Сонгинохайрхан дүүрэг 2, Сүхбаатар дүүрэг 1, Чингэлтэй дүүрэг 12 мэдээлэл мэдээлээгүй байна.

Мэдээлээгүй буюу хугацаа хоцроосон мэдээллийг мэдээллийн *төрлөөр* нь авч үзвэл:

/сая төгрөг/

| Д/д | Шилэн дансны мэдээллийн төрлийн нэр | Нийт мэдээлэх | | | Хугацаандаа оруулсан | Хугацаа хоцорсон мэдээлэл | | | Мэдээлээгүй | | | Нийт мэдээлэл байршуулсан хувь | Хугацаандаа мэдээлэл байршуулсан хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Мэдээллийн тоо | Шийдвэр, гүйлгээний тоо | Мөнгөн дүн | | Мэдээллийн тоо | Шийдвэр, гүйлгээний | Мөнгөн дүн | Мэдээллийн тоо | Шийдвэр, гүйлгээний | Мөнгөн дүн | | |
| 1 | Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-Эдийн засгийн ангилал | 288 | 288 | 78,009.9 | 283 | 5 | 4 | 578.4 | - | - | - | 100% | 98% |
| 2 | Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл-Хөтөлбөр, зориулалт | 288 | 282 | 78,009.9 | 283 | 2 | 2 | 249.8 | 3 | 3 | 864.4 | 99% | 98% |
| 3 | Санхүүгийн тайлан /2024 оны жилийн эцэс, 2025 оны эхний хагас жил/ | 64 | 67 | 83,741.5 | 57 | 3 | 4 | 7,583.6 | 4 | 2 | 3,111.9 | 94% | 89% |
| 4 | Хандив, тусламжийн орлого | 64 | 3 | 216.7 | 64 | - | - | - | - | - | - | 100% | 100% |
| 5 | Хандив, тусламжийн зарцуулалтын тайлан | 64 | 2 | 148.2 | 64 | - | - | - | - | - | - | 100% | 100% |
| 6 | Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшууллалд зарцуулсан тайлан | 64 | - | - | 64 | - | - | - | - | - | - | 100% | 100% |
| 7 | Байгууллагын батлагдсан төсөв | 32 | 32 | 74,562.1 | 18 | 14 | 10 | 34,001.4 | - | 1 | 165.6 | 100% | 56% |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | Дараа жилийн төсвийн төсөл | 32 | 32 | 91,281.9 | 30 | 1 | - | - | 1 | - | - | 97% | 94% |
| 9 | Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /2024 оны жилийн эцэс/ | 32 | 9 | 360.0 | 29 | 2 | 1 | - | 1 | - | - | 97% | 91% |
| 10 | Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ | 288 | 533 | 45,988.1 | 221 | 54 | 119 | 10,700.8 | 13 | 47 | 1,782.7 | 95% | 77% |
| 11 | Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ | 288 | 926 | 8,836.8 | 222 | 37 | 115 | 2,077.9 | 29 | 112 | 1,978.0 | 90% | 77% |
| 12 | Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт | 288 | 133 | 80,568.5 | 277 | 8 | 13 | 10,851.8 | 3 | 4 | 6,273.6 | 99% | 96% |
| **ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛ** | | 1,792 | 2,307 | 541,723.5 | 1,612 | 126 | 268 | 66,043.7 | 54 | 169 | 14,176.1 | 97% | 90% |
| 1 | Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл | 288 | 4 | 62.9 | 288 | - | - | - | - | - | - | 100% | 100% |
| 2 | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө | 32 | 47 | 958.2 | 22 | 9 | 27 | 196.0 | 1 | 2 | 32.5 | 97% | 69% |
| 3 | Худалдан авах ажиллагааны тайлан /2024 он/ | 32 | 66 | 925.7 | 30 | 1 | 1 | 53.8 | 1 | - | - | 97% | 94% |
| 4 | Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт | 32 | 1 | 15.0 | 32 | - | - | - | - | - | - | 100% | 100% |
| 5 | Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл | 288 | 1 | 15.0 | 288 | - | - | - | - | - | - | 100% | 100% |
